

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК – НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус компани нь Баян-Өлгий аймгийн төв бүх айл өрх, албан байгууллагуудад дулааны эрчим хүч үйлдвэрлэж түгээдэг.

2021 онд 105 хүний бүрэлдэхүүнтэйгээр эрчим хүчний зохицуулах хорооноос авсан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Тус компаниас худалдан борлуулах дулааны эрчим хүчний үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооноос 2021 оны 10 сарын 14 өдрийн 466 тоот тогтоолын дагуу мөрдөж ажиллаж байна.

Дээрх тогтоолын хавсралтад зааснаар дулааныг нэмэгдсэн өртгийн албан татваргүйгээр албан байгууллагуудад 1600, орон сууцанд амьдардаг айл өрхүүдэд 800 төгрөг, ААНэгжүүд 1200 төгрөгөөр борлуулж байна.

Тус бүр 13Гкал/цаг – ийн хүчин чадалтай КЕ25-14 маркийн 3 зуух болон 20 Гкал/цаг - ийн хүчин чадалтай КВТС-20-150 маркийн 1 зуухтайгаар ажиллаж байна. КЕ25-14 нэг зуухыг тоног төхөөрөмжийг шинэчилж 2021 оны 01 сард ашиглалтанд оруулав. Үлдсэн 3 зуухаар өлгийн горим ажиллагааг хэвийн хангав.

Нийт 1761 хэрэглэгчээс айл өрх 1321, хувийн амины орон сууц 211, төсөвт байгууллага 48, аж ахуйн нэгж 181 байна.

Тайлант хугацаанд 34,590,650.83 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч 1,098,505,021.72 төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 570,459,829.35 төгрөгийн, НДШ-ийн өглөг 18,874,778.96 төгрөг, банкнаас авсан богино хугацааны 7,420,209.67 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, урт хугацаат зээл 3,477,987,862.95 төгрөг байна.

2021 онд мөнгөн хөрөнгө 18,383,218.93, дансны авлага 1,293,945,789.81 ,бусад авлага 618,140,749.85 бараа материал 502,345,515.57 урьдчилж төлсөн орлого 24,232,751.71 эргэлтийн хөрөнгийн нийт дүн 2,457,048,025.87 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө 6,937,714,730.69 биет бус хөрөнгө 107,719,560 эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн 7,045,434,290.69 нийт хөрөнгийн дүн 9,502,482,316.56 төгрөг байна.

Мөнгөн зарлагын дүн 4,975,172,798.57 төгрөг байгаагаас ажилчидад олгосон мөнгөн зарлага 759,575,090, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө 177,171,536 бараа материал худалдан авахад төлсөн мөнгө 360,511,551, ашиглалтын зардалд төлсөн мөнгө 302,276,075, түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн үнэд 1,727,825,083.5 хүүд төлсөн 642,430,780.4 татварын байгууллагад 189,164,289.1 төгрөг, даатгалын төлбөрт 4,335,532.2 төгрөг тус тус төлсөн байна.

Компанийн 2021 оны санхүүгийн тайланг 2021 оны 12 сарын 31 – ний өдрөөр тасалбар болгон гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Аккурэйт-аудит” ХХК – иар аудит хийлгэсэн болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НЯ-БО



М. ТИЛЕУБЕРДИ
К. ЕРБОЛАТ